

ДЭН СЯОПИН МОНГОЛЫН ГОВИЙГ ТУУЛСАН НЬ

*Л.Бэгзжав**

Дэн Сяопиний 5 хүүхдийн дөрөвдэх нь болох Дэн Сяожун 1950 оны 1-р сарын 25-нд Чуншин хотноо төржээ. Дээрээ хоёр эгчтэй, нэг ахтай, шалимгар шар үстэй эзгээр охиноо эх нь өхөөрдөн Мао Мао (ноос, үс гэсэн утгатай үг) хэмээн нэрийдсэн агаад доороо нэг дүү дагуулжээ.

Хүний ертөнцөд ирсэн үеэс нь түүнд ер бусын хувь заяа тохиож эргэн тойронд нь агуу их үйл явдал өрнөж, түүхийн олон мартагдашгүй үйл явдлын гэрч болж, нийгэмд танигдсан Дэн Сяопин 16 настайдаа түүхэн зүтгэлтнүүдтэй танил болох таньж мэдэх онцгой байдалд өсчээ. Тэрбээр эргэцүүлэл бодол, эргэн санах дурсамжаа мартахгүй байхын тулд онцгойлон эцгийнхээ тухайд сэтгэлдээ тээж явдаг бүхнээ цаасан дээр буулган “Миний эцэг-Дэн Сяопин” хэмээх томоохон бүтээл туурвижээ.

Түүний эцгийн анхны овог нэр Дэн Сяньшэн, сургуульд орсны дараа Дэн Сисянь гэж өөрчилсөн бөгөөд Дэн Бинь гэдэг нууц нэрээ ч олонтаа хэрэглэж байгаад хожим нэрээ өөрчлөн Дэн Сяопин гэх болжээ.

Хүний өвөг дээдэс 2 сая жилийн өмнө амьдарч байсан, Хятадын эртний соёл иргэншлийн түүхт Сычуань мужаас түүхийн тавцанд нэрээ үлдээсэн эрдэмтэн мэргэд, бичгийн хүмүүс, билиг авьяастан олон төрсний дотроос Хань улсын найрагч Сыма Сянжу Тан улсын алдарт шүлэгч Ли Бай, Ду Фу, Байлдаант улсын үеийн хиймэл усжуулалтын агуу их мастер эцэг хүү Ли Бин гэх мэт оюунлиг сод хүмүүсийг нэрлэж болно. Эдүгээ Хятадын засаг захиргааны хамгийн том муж, 100 сая давсан хүн амтай Сычуаний ард түмэн газар боловсруулах, хүр хорхой үржүүлэх, төмөр хайлах, торгон эд нэхэхээрээ, бэрхшээлийг давах, тэвчээр хатуужил, хөдөлмөрт шаргуу, ов мэхгүй, элдэв зальжин зангүйгээрээ эртнээс алдартай. Чухам энэ л нутгаас XX зууны дэлхийн агуу хүмүүсийн нэг, Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын уран барилгач гэгдсэн Дэн Сяопин төрсөн түүхтэй.

1904 оны 8-р сарын 22-нд Сычуань мужийн Гуаньянь хошууны Сесин балгасны Пайфан тосгонд төрсөн хүүд Дэн Сяньшэн гэдэг нэрийг эцэг Дэн Вэньмин нь өгчээ.

5 настай хүүгээ хуучны хувийн сургуульд оруулахад багш нь нэрийг нь Дэн Сисянь гэж өөрчилсөн ба 25 нас хүртлээ энэ нэрээрээ явжээ. Тэрбээр 6 настайдаа хошууныхаа бага сургуульд орж, 14 настайдаа дунд сургуульд оржээ.

Хошууныхаа бага сургуульд Күнз, Мэнзийн “гурван үсэг, дөрвөн бичиг, таван ном”-ыг утгыг үл ойлгон тангад ном шиг цээжилж 9 жил суралцаад дунд сургуульд орсон Дэн Сяопиний хүүхэд ахуй нас нь Мао Мао охиных нь бодлоор, агуу их хүмүүс хүүхэд, идэр насандаа авьяас билиг нь тодрох нь цөөнгүй ч түүний эцэг ердийн нэгэн л байжээ. Зарим садан төрөл, нутгийнхан нь түүний хүүхэд насны тухай сайхан түүх өгүүлдэг

* Л.Бэгзжав - ОУСХ-ийн Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор

ч түүнд итгэхийн аргагүй, гагцхүү, эцэг эхээ хайрладаг сайн хүү, эрдэм номдоо хичээнгүй сурагч байсныг баталж болох ажээ.

Дэн Сяопин арван зургаахан настайдаа эх нутгаа орхиж, тэнгис далайг гатлан хүсэл мөрөөдлийнхөө эрэлд хөтлөгдөн холын Францад оджээ. Цэл залуу 18 насандаа коммунист үзлийг даган эх орноо, ард түмнээ аврах үйл хэргийн төлөө тангараг өргөснөөс хойш, мэргэжлийн хувьсгалт үйл ажиллагааныхаа 70 гаруй жилийн явцад нууц байдал дахь ажлыг зохион байгуулагч, цэргийн командлагч, засаг төрийн хариуцлагатай албан тушаал хашиж, намд удирдах чухал ажил гүйцэтгэж ирсэн юм. Хятадын түүхийн урт удаан он дарааллын түүх түүний нэртэй салшгүй нягт холбоотой. Нам, төрийн өндөр албан тушаалаасаа хоёронтаа авахуулж, гурвантаа дэвшиж “Хятадын түүхийн хог дээр үүрд мөнх” хаягдаж байсан ч Хятад орон, Хятадын ард түмнийг хөгжил дэвшлийн шинэ замд хөтлөн өнөөгийн өндөрлөгт хүргэх онол, практикийг хэрэгжүүлэгч нь чухамхүү Дэн Сяопин гэдгийг дэлхий дахинаа нэгэнт хүлээн зөвшөөрчээ.

Дэн Сяопин 1918 оны намар Чунцин хотноо Францад суралцаж ажиллах залуусыг бэлтгэх сургуульд орж, франц хэл, томьёоны ухаан, хэмжихүйн ухаан, бодисын зүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үндэс хичээл үзэж, ертөнцийг таних оюунаа тэлжээ. “Аж үйлдвэр Хятад орныг аварна” хэмээн ухаарч, хоёр жил суралцаад уг сургуулиа дүүргэсэн байна. Чунциний бэлтгэл сургууль төгсөгчдөөс шигшиж авсан 83 хүүхдийн тоонд Дэн Сяопин багтан 1920 оны 9 сарын 11-нд Францын “Андре Лебон” хөлөг онгоцоор Шанхайгаас Парижийг зорьжээ. Тэрбээр Марсел, Байе, Париж, Лион хотуудад “Шнайдер” зэвсгийн үйлдвэрт ган цувималч, “Рено” машины үйлдвэрт слесарь, резин гутлын үйлдвэрийн ажилчин зэрэг хөдөлмөр эрхэлж, энэ завсар 20 настайдаа ХКН-д элсэж Францад 5 жил 2 сар 19 өдөр амьдарч, сурлага ажлын амаргүй зам туулж коммунист нам, эвлэлийн байгууллагын ажилд оролцон, хувьсгалт тэмцлийн зам сонгон авчээ. Францыг орхих үедээ 22 настай байсан тэрбээр хувьсгалт тэмцлийн туршлагатай, коммунист бат итгэл үнэмшилтэй, мэргэжлийн хувьсгалч болон төлөвшсөн байна.

Хятадад “цаг үе баатруудыг төрүүлнэ” гэсэн үг байдаг. Хятадын хувьсгалын их давалгаа, ХКН байгуулагдсан цагаас хойш олон авьяаслаг хүмүүс, баатруудын үе төрөн гарчээ. Зөвхөн Францад гэхэд л Хятадын ард түмнийг чөлөөлөх үйлсэд амь биеэ зориулсан хувьсгалыг манлайлагч, гялалзсан оддын бүхэл бүтэн үе төрөн гарсан юм. Хожмоо Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд болсон Жоу Энълай, Төрийн Зөвлөлийн орлогч сайд, цэргийн зөвлөлийн дарга Дэн Сяопин, Маршал Чэнь И, Не Рунжэнь, Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Ли Фучунь гэх мэт хэдэн арван хүнийг нэрлэж болох юм.

1925 оны 5-р сард ХКН-ын Европын секц 20 нөхдийг Францаас ЗХУ-д сургахаар явуулсаны дотор Дэн багтсан байв. Мөн оны эцсээр Сунь Ятсений нэрэмжит Дорно дахины хөдөлмөрчдийн Их сургуульд (КУТВ) 310 сурагчийг Хятадаас Москвад илгээжээ. Хятад оюутнууд орос хэл голлон үзэхээс гадна 7 хоногт 4 цагаар 6 удаа, эдийн засаг, түүх, орчин үеийн үзэл

суртлын асуудал, Оросын хувьсгалын онол практик, Үндэсний ба колонийн асуудал, Хятадын нийгмийн хөгжлийн асуудал зэрэг заавал судлах хичээлд шамдан суралцаж байжээ. Тэр үеийн намын гишүүдийн тодорхойлолтонд: “Овог нэр: Дэн Сисянь, Орос нэр: Дроздов, оюутны үнэмлэх №33, намын ажил: хэсгийн намын зохион байгуулагч, суртал ухуулга зохион байгуулалтын ажил эрхлэхэд илүү тохирно” гэх зэргээр дурджээ.

Франц, Зөвлөлтөд байсан он жилүүддээ Дэн Сяопин гадаад ахуйн зан заншилд дадаж өрнөдийн сэтгэлгээ, хэв маягаас суралцсанаас гадна төмс, франц вино, бяслаг, кофе, талх гээд хоол хүнсийг ч хэрэглэх дуртай, хөл бөмбөгт хорхойтой нэгэн болсныг түүний намтарт дурссан байдаг.

Сунь Ятсений сургуульд жил гаран болоод байхад нь Хятадын хувьсгалд оролцуулахын тулд түүнийг нутгаас нь дууджээ. Тэрээр 1926 оны эцсээр Москвагаас Хятадад буцах замдаа Монголын их говиор дайран өнгөрснийг түүний охин Мао Мао “Миний эцэг-Дэн Сяопин” номдоо өгүүлжээ.

Дэн Сисянь 20 гаруй хүнтэй Фэн Юйсяний цэрэгт орж Москвагаас томилогдсон анхны хэсэгт орсон юм. Тэд эхлээд Москвагаас Верхнеудинск хүртэл галт тэргээр явж, дараа нь машинаар Улаанбаатар хүртэл явжээ. Цааш явахад суудал багтахгүйн улмаас эхлээд гурвуул замд гарчээ. Энэ нь коммунист Дэн Сисянь, коммунист залуучуудын эвлэлийн гишүүн Ван Чунъюнь, Жу Шихэн нар байлаа. Тэд Зөвлөлтийн жолооч нарын Фэн Юйсяний армид Зөвлөлтийн зэр зэвсгийг зөөвөрлөж байсан 3 ачааны машинд сууж явжээ.

Улаанбаатараас Бугат хүртэл 800 км газрыг, өнөөдөр нисэх онгоцоор нэг цаг нисэх бөгөөд, тэр үед Монголын тал нутаг одоогийнхтай адилгүй, өтгөн сахлаг өвстэй, хонь, үхэр сүрэг хэдэн зуун км-т тархан бэлчиж байжээ. Цас мөсөөр хучигдсан энэ газар хатуу ширүүн өвөл болж, хүйтэн салхи яс янгинам үлээж байв. 3 машин замгүй газраар туучин, хүмүүс өөрсдөө машинаа түлхэж, өдөрт хэдхэн км газар туулж байв. Замд өлсөж, даарч хуурай хүнсээр хооллож, аргал түүж гал түлж явжээ.

Эцэст нь тал нутаг ард үлджээ. Гэвч аялагчдыг өөр нэг саад элс хүлээж байв. Элстэй газар орон тал газраас илүү цөлжилттэй өвсгүй, усгүй, мод ч үгүй салхи дэгдэхэд тэнгэрт тултал тоос манарна. Шатам халуун наранд хүн амьтангүй шар элсэн далай цэлийнэ. Элсэнд шигдсэн машинаа тэмээгээр татна. Урт удаан 8 өдөр 8 шөнө өнгөрч, энэхүү хязгаар хяргахгүй үхлийн далайг сая нэг гатлав.

Дэн Сисянь нөхдийн хамт нэг сар гаруй явж эцэст нь Баруун хойт Хятадын Нинсягийн Иньчуань хотод очжээ. Замд явсан энэ бүх хугацаанд нэг удаа ч нүүрээ ч угаагаагүй гэж аав ярьж байсан. Энд хэсэг амсхийгээд, тэд унаа сэлгэн морь унаж Ганьсу-Шэньси-ийн замаар өдөр шөнөгүй довтолгон 1927 оны 2-р сард Сиань хотноо сая нэг хүрчээ.

Аавын ярьснаар, 20 гаруй нөхөр Москвагаас гарч Монголын тал элсэн говийг туулан, Баруун хойт Хятадын Сиань-д ирэхэд хамаг хувцас нь цоорхой ноорхой навтарга болжээ.

Түүний охин ийн өгүүлжээ.

Тэр үеийн Монгол орон Хятадын хувьсгалчдын дамжин өнгөрөх гол зангилаа, Зөвлөлт Холбоот Улс болон Коминтернтэй, харилцах гүүр болдог чухал газар байлаа. Хятадын олон арван хувьсгалчдын, тэр дундаа Дэн Сяопиний намтрын нэгээхэн хуудас Монголтой ийн холбогдож байжээ. БНХАУ байгуулагдахаас өмнөх МАХН, ХКН-ын харилцааны түүх, хоёр орны хувьсгалчдын хэлхээ холбооны түүхийг нэхэн сурвалжлах, Хятадын хувьсгалд Монголчуудын үзүүлсэн тал бүрийн шууд болон дам туслалцааг тодруулах явдал ХХ зууны Монгол-Хятадын харилцаанд багагүй чухал байр суурь эзлэх учиртай.